



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН
ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 182/ШШ2019/00433

Улаанбаатар хот

Хариуцагчийн зөвшөөрлийг баталж,
хэргийг хэрэгсэхгүй болгох тухай

Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч
Н.Нарангэрэл би,

Нэхэмжлэгч: Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо, Нью майнд групп ХХК-ийн
байранд байрлах, /улсын бүртгэлийн дугаар 9010002001, регистрийн дугаар
5039754/, Лэндмн ББСБ ХК-ийн нэхэмжлэлтэй,

Хариуцагч: Чингэлтэй дүүрэг, 10 дугаар хороо, Дэнж 33 гудамж 4836 тоот
хаягт оршин суух, /регистрийн дугаар ОС88100701/, Бух овогт Сүрэнбаатарын
Баттунгалагт холбогдох,

Зээлийн гэрээний үүрэгт 207,933 төгрөг гаргуулах тухай иргэний хэргийг
хянаад

ТОДОРХОЙЛОХ нь:

Нэхэмжлэгч Лэндмн ББСБ ХК шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ: С.Баттунгалаг
нь 2017 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр 35676 дугаартай цахим зээлийн эрх нээх
гэрээг байгуулсан. С.Баттунгалагийн Lendmn аппликейшнаар дамжуулан гаргасан
хүсэлтийн дагуу 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр 180,000 төгрөгийн зээлийг
11,100 төгрөгийн шимтгэлтэй, 30 хоногийн хугацаатай 2018 оны 02 дугаар сарын 22-
ны өдөр бүрэн эргэн төлөх нөхцөлтэй, 180,000 төгрөгийг С.Баттунгалагийн Хаан
банкны 5017123858 тоот дансанд шилжүүлсэн. Иймд С.Баттунгалагаас үндсэн
зээлийн төлбөр 180,000 төгрөг, шимтгэл 11,100 төгрөг, нотариатын үйлчилгээний
төлбөр 16,833 төгрөг, нийт 207,933 төгрөгийг гаргуулахаар нэхэмжилсэн. Хариуцагч
С.Баттунгалагийн тайлбартай танилцаад зөвшөөрч байх тул хэргийг
хялбаршуулсан журмаар шийдвэрлэж өгнө үү гэжээ.

Хариуцагч С.Баттунгалаг шүүхэд бичгээр гаргасан хариу тайлбартаа:
Лэндмн ББСБ ХК-ийн нэхэмжилсэн 207,933 төгрөгийг төлөхийг хүлээн зөвшөөрч
байна. Уг 207,933 төгрөгийг 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор төлж
барагдуулна. Иймд хэргийг хялбаршуулсан журмаар шийдэж өгнө үү гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Нэхэмжлэгч Лэндмн ББСБ ХК хариуцагч С.Баттунгалагт холбогдуулан
зээлийн гэрээний үүрэгт 207,933 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлага
гаргажээ.

Талуудын хооронд 2017 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр 35676 тоот цахим
зээлийн эрх нээх гэрээ байгуулагдаж, 180,000 төгрөгийг 130 хоногийн хугацаатай

2018 оны 02 дугаар сарын 22-ны өдөр эргэн төлөх нөхцөлтэй, 11,100 төгрөгийн шимтгэлтэй зээлсэн тухайд маргаагүй байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хүлээн зөвшөөрч, 207,933 төгрөгийг 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор төлж барагдуулахаар хариу тайлбар шүүхэд ирүүлсэн нь хуульд нийцсэн, гуравдагч этгээдийн ашиг сонирхлыг хөндөөгүй байх тул хариуцагчийн зөвшөөрлийг баталж, хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх үндэстэй байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2, 75 дугаар зүйлүүдэд заасныг удирдлага болгон

ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Лэндмн ББСБ ХК-ийн нэхэмжлэлтэй хариуцагч С.Баттунгалагт холбогдох зээлийн гэрээний үүрэгт 207,933 төгрөг гаргуулах тухай иргэний хэргийн хариуцагч 207,933 төгрөгийг 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор төлж барагдуулахаар нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хүлээн зөвшөөрснийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

2.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.5, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх хэсэгт зааснаар нэхэмжлэгчийн улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 6887.99 төгрөгийг Улсын орлогод хэвээр үлдээж, Улсын орлогоос 3,444 төгрөг, хариуцагч С.Баттунгалагаас 3,444 төгрөгийг гаргуулж нэхэмжлэгч Лэндмн ББСБ ХК-д олгосугай.

3.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.6 дахь хэсэгт зааснаар захирамжийг хариуцагч сайн дураар биелүүлээгүй тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуульд заасан үндэслэл журмын дагуу шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулахыг Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт зөвшөөрсүгэй.

4.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.4 дэх хэсэгт зааснаар зохигч давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, тухайн асуудлаар анхан шатны шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрхгүй болохыг дурдсугай.

ШҮҮГЧ



Н.НАРАНГЭРЭЛ